

# Vulcan MineModeller Open Pit

Vulcan MineModeller Open Pit ил уурхайн болон овоолгын загвар, гадаргуугийн боловсруулалт болон нөөцийн тооцоолол зэрэг газрын гадаргын үйл ажиллагааг гүйцэтгэхэд шаардлагатай хэрэгслүүдийг агуулдаг. Өдөр тутмын олборлолтын тайланг гаргахад шаардлагатай гадаргуугийн болон уурхайн загварын өгөгдлийг хялбархан шинэчлэх боломжтой

## Үндсэн модуль

### Гурвалжлалын арга

- Газрын гадаргын модель, уурхайн загвар зэрэг гурвалжлал болон гурван хэмжээст гадаргууг үүсгэх, засварлах
- Контур байгуулах
- Гурвалжлал болон зургийг давхцуулж дүрслэлийг сайжруулах

### Vulcan 3D CAD хэрэгсэл

- Шулуун, полигон, цэг болон текстийг байгуулах
- Гурван хэмжээст өгөгдлийг интерактив хэлбэрээр засварлах, харах болон дүн шинжилгээ хийх

### Мэдээлэл дамжуулах

- Vulcan болон бусад програмууд руу өгөгдөл оруулах, гаргах
- SQL Server™, Oracle® and MS Access™ зэрэгтэй ODBC холбогдох

### Хэвлэлтэнд бэлтгэх

- Зургийн хүснэгт, хэрэглэгчийн цонх зэрэг хэрэглэгчийн тодорхойлсон зургийн хэлбэрийг өөрчлөх
- Зургийн файлуудыг (plot files) засварлах, дахин үүсгэх
- Wizard хэлбэрийн интерфэйс ашиглан ганц зургийг үүсгэх, тохиргоо хийх
- Хэд хэдэн зургийг бэлэн байгаа өгөгдлийн үзүүлэлтүүдийг ашиглан batch загварын интерфэйсээр үүсгэх

## Нэмэх боломжтой модулиуд

- + Pit Optimiser
- + Grade Control
- + Cut-off Grade Optimiser
- + Dragline
- + Haulage Profile
- + Chronos Scheduler
- + Survey
- + Interactive Polygon Reserver
- + Drill & Blast Design
- + Interactive Road Design
- + Short Term Planner

## MineModeller Open Pit модуль

### Торлолын модель

- Торлол бүхий гадаргуу байгуулах төрөл бүрийн хүчирхэг загварчлалын аргууд
- Нарийн төвөгтэй торлол байгуулах, түүнийг боловсруулах, засварлах
- Автоматжуулсан моделийн процессийг ашиглан давхаргын, структурын болон агуулга/чанарын торлолын модель үүсгэх
- Ашиглалтын нөөцийн хүрээг үүсгэхийн тулд полигоныг торлолын дээр давхарлаж ашиглалтын нөөцийг үүсгэх, түүнд дүн шинжилгээ хийх

### Статистик

- Vulcan өгөгдлийн сан, торлол болон блок моделиудад статистик анализ хийх
- Автоматаар дүн шинжилгээний үр дүн, графикийг Microsoft® Excel™ гаргах

### Блок модель

- Энгийн нүд (cell), дэд нүд (subcell) болон бусад хувьсагчуудаар дамжуулан мэдээллийг ашиглах, хадгалах
- Урвуу зайн аргаар агуулга тооцоолох
- Олон тооны блокуудыг дэмжиж ажиллах. Хувьсагчуудыг нэмэх, засварлах, устгах
- Хүдрийн агуулга, тонны графикийг багтаасан тусгайлсан тайлан боловсруулах

### Ил уурхайн загвар

- Олон траншей болон хэд хэдэн налуу бүхий нарийвчилсан уурхайн загварыг хийх хэрэгсэл
- Хэд хэдэн уурхайн үе шат болон овоолгыг загварчлах
- Нөөцийн модельд урвуу зайн аргаар агуулгын интерполяци хийх
- Уурхайн загварын эдийн засгийн, тоон болон эзэлхүүний үнэлгээ хийх
- Стратегийн уурхайн загварын үнэлгээг хийх Rapid Pit Design хэрэгсэл
- Давхаргын загварчлалын үе шатуудыг хадгалах, давтан ашиглах

